ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаад харилцааны яамны дэргэдэх салбар зөвлөл /цаашид “Салбар зөвлөл” гэх/ нь Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/, Дипломат албаны тухай хууль, холбогдох хууль, тогтоомж, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол болон бусад заавар, чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, тайлангийн хугацаанд дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөөт ажлаа бүрэн биелүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Салбар зөвлөлийн 4 удаагийн хуралдааныг зохион байгуулж, Салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, ажилд томилох, ДТГ-т ажиллах томилолтын хугацаа нь дууссан ажилтныг эгүүлэн татах, томилох, албан тушаалаас нь түдгэлзүүлэх, дэвшүүлэн томилох зэрэг яам, ДТГ-ын холбогдох асуудлыг шийдвэрлэж, салбарын нийт албан хаагчдад цахим хэлбэрээр дотоод мэдээ болгон хүргүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллав. 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрүүдийг Сайдын 7 тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 62 тушаалаар /давхардсан тоогоор/ албажуулаад байна.

Салбар зөвлөлийн шийдвэрээр 2021 онд ДТГ-т ажиллах томилолтын хугацаа нь дуусч буй 36 дипломат ажилтан, 22 үйлчилгээ техникийн ажилтан, ДТГ-ын тэргүүн, ажилтнуудын хүсэлт, ажлын хэрэгцээ шаардлага, үндсэн байгууллагын саналыг харгалзан 2 ажилтныг албан тушаал дэвшүүлж, ДТГ-т ажиллуулахаар 36 дипломат, 23 үйлчилгээ, техникийн ажилтныг томилов. Түүнчлэн Монгол Улсаас гадаад улсад суугаа 19 Элчин сайдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас гадаад улсад суух 23 Элчин сайдыг тус тус томилох асуудлыг эрх бүхий дээд шатны байгууллагаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв.

Салбарын үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд Төрийн албаны тухай хууль, УИХ, Засгийн газрын эрх зүйн актуудын талаарх мэдээллийг яамны нийт албан хаагчдад тухай бүр хүргүүлэн ажиллав.

Гадаад харилцааны яамны төрийн захиргааны гүйцэтгэх 9 газрын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 82 дугаар тогтоолоор батлав. Үүнд: Бодлого, төлөвлөлтийн газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Олон талт хамтын

ажиллагааны газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Төрийн захиргааны удирдлагын газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Олон улсын гэрээ, эрх зүйн газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Консулын газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Дипломат ёслолын газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын атташегийн албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр хавсралтаар тус тус батлав. Түүнчлэн, батлагдсан албан тушаалын тодорхойлолттой уялдуулж яам, ДТГ-ын албан хаагчдын төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах чиглэл, заавар, зөвлөмжийг хүргүүлж, салбарын нийт дипломат болон төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байгаа болно. Эдгээр албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалт зарлан дипломат албаны тусгай шалгалтыг авах бэлтгэлийг Салбар зөвлөлөөс хангаад байна.

Албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд онцгойлон анхаарч, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд ажлын хариуцлага алдсан ДТГ-ын 1 албан хаагчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэв.

АНУ-ын Чикаго хотод Консулын газар нээх асуудлыг Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, асуудлыг УИХ-ын холбогдох байнгын хороотой зөвшилцөх шийдвэр гаргуулсны дагуу УИХ-ын АБГББХ-ны 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гаргуулаад байна. Энэ хүрээнд америкийн талаас Консулын газрыг нээх зөвшөөрлийг хүсч, айлын талаас ноот бичгээр зөвшөөрлийг олгоод байгаа бөгөөд тус хотод Консулын газрын нээх УИХ-ын тогтоолын төслийг 2021 оны УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлж, 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдөр “Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Монгол Улсын Консулын газар нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн батлав.

Салбарын албан хаагчдын хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор 2017 онд ашиглалтад оруулсан “Хүний нөөцийн удирдлагын програм"-д хүний нөөцийн тушаалын мэдээлэл, лавлагаа, эрэлт хайлт, тайлан боловсруулах зэрэг хөгжүүлэлтийг дотоод судалгаандаа тулгуурлан зохиолгож, 2016 оноос хойших Гадаад харилцааны сайд, Төрийн нарийн бичгийн даргын боловсон хүчин, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнд хамаарах тушаалуудын цахим ашиглалтын санг бүрдүүлэв. Түүнчлэн, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, мэдээлэл авах нэгдсэн системд ГХЯ, ДТГ-уудын нийт албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж байна.

2021 онд эхний хагаст яамны шуурхай зөвлөлгөөнийг 17 удаа зохион байгуулж, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, арга зүйгээр хангах, ажилтнуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, сахилга батыг сайжруулах талаар нийт 131 заалт бүхий үүрэг даалгаварыг яамны газар, нэгж болон ДТГ-уудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Салбарын албан хаагчид ХАСХОМ-ээ жил бүр цахимаар мэдүүлэх үүрэгт ажлын хүрээнд 2020 оны 2 дугаар сарын 15-ны байдлаар Гадаад харилцааны яамны төв аппарат болон ДТГ-ын нийт 318 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг баталгаажуулж, ХАСХОМ-1, ХАСХОМ-2, тайлангуудыг АТГ-т хүргүүлсэн. Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасны дагуу 2021 оны эхний хагас жилийн байдлаар тус яамнаас хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт томилогдон ажиллах болон тус яамны зарим албан тушаалд ажиллах 78 албан хаагчийн ХАСУМ-ийг гаргуулан авч, Авлигатай тэмцэх газраар хянуулаад байна.

Тайлангийн хугацаанд Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангах асуудлын хүрээнд нууцтай танилцах эрх бүхий 7 албан тушаалтныг аюулгүй байдлын шалгалтад оруулж, холбогдох зөвшөөрлийг авав.

2021 оны эхний хагас жилд гадаад харилцааны салбарт хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр салбарын хэмжээнд нийт 25 ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 174 зөвлөмж өгч, 66 танилцуулга боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан болно. Гадаад харилцааны салбарт хамаарах 179 хууль тогтоомжийн 326 зүйл, заалтын хэрэгжилтийн биелэлт 90.2 хувьтай, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 71.32 хувьтай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт 92.5 хувьтай гарав. Дээд, өндөр түвшний 2015-2020 оны 67 айлчлалын 1133 заалт бүхий төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөв.

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт **“**Дипломат албанд сахилга, хариуцлагыг эрс нэмэгдүүлэх” зорилт дэвшүүлсний дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудалд онцгой анхаарал хандуулж **“Дипломат албан тушаал эрхлэх болзол”-ыг шинэчлэн боловсруулж, Сайдын 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн А/03 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна.** Хилийн чанад дахь ДТГ-т томилогдон ажиллах албан хаагчдад тавигдах шалгуурыг өндөрсгөх, хяналтыг сайжруулах зорилгоор “ДТГ-т томилогдон ажиллах албан хаагчдын бэлтгэл ажлын удирдамж”-ийг Гадаад харилцааны сайдын 2019 оны А/63 дугаар тушаалаар шинэчлэн баталж, албан хаагч бүр “эрүүл мэндийн багц шинжилгээ”, тэр дундаа мансууруулах бодисын шинжилгээ хийлгэх” заалт оруулж, шинжилгээний хариу гарсны дараа

томилох асуудлыг эцэслэн шийдвэрлэх зохицуулалтыг шинээр нэвтрүүлэн мөрдөж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор албан хаагчдын 2019-2021 онд холбогдсон хэрэг, зөрчлийн судалгаа гаргаж үзэхэд дипломат эрх ямба, дархан эрхээ урвуулан ашиглах замаар хувийн ашиг хонжоо олох зорилготой гэмт хэргийн шинжтэй зөрчилд ДТГ-ын 5 албан хаагч, авлига авах гэмт хэргийн шинжтэй зөрчилд ДТГ-ын 1 албан хаагч, хүлээн авагч улсын хууль тогтоомжийг зөрчиж, автомашин хууль бусаар хилээр нэвтрүүлэн бусдад дамлан худалдах гэмт хэргийн шинжтэй зөрчилд ДТГ-ын 1 албан хаагч, төсвийн хөрөнгө завшсан гэмт хэргийн шинжтэй зөрчилд ДТГ-ын тэргүүнээр ажиллаж байсан 1 албан хаагч, үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрөөгүй ажил эрхэлсэн зөрчилд яамны 2 албан хаагч, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэгтээ хайнга хандсан, үүргээ биелүүлээгүй зөрчилд яам, ДТГ-ын 6 албан хаагч, харьяа дээд шатны албан тушаалтнаас өгсөн үүрэг, удирдамжийг зөрчсөн ДТГ-ын 3 албан хаагч, хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлээгүй зөрчилд яамны 1 албан хаагч, ажил тасалсан, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчилд ДТГ-т ажиллаж буй төрийн үйлчилгээний 2 албан хаагч тус тус холбогдсон бөгөөд тэдэнд дараахь сахилгын шийтгэл ногдуулсан. Үүнд:

Он	Сануулах	Албан тушаалын цалин бууруулах	Албан тушаалаас түдгэлзүүлэх	Дипломат албанаас халах
2021	-	-	1	1

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн сурталчилгаа 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэхтэй холбогдуулан Төрийн албаны тухай хуулиар төрийн жинхэнэ албаны албан хаагчдын үйл ажиллагаанд хориглосон зүйлүүдийг зөрчихгүй байх, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5, 39.1.13 дахь заалтууд, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-ийн холбогдох заалтуудыг чанд мөрдөж ажиллах, тухайлбал, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих хэвлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээхгүй байх төрийн жинхэнэ албан хаагчийн үүрэг, сахилгын хэм хэмжээг зөрчихгүй байх анхааруулга, чиглэлийг яамны нэгжийн удирдлагууд, ДТГ-уудын тэргүүн нар, төрийн жинхэнэ албан хаагчдад Төрийн нарийн бичгийн даргын гарын үсэг бүхий цахим шуудангаар хүргүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд хилийн чанад дахь ДТГ-т ажиллахаар томилогдсон албан хаагчдад хувийн ашиг хонжоо олох зорилгоор дипломат эрх ямба, дархан эрхээ урвуулан ашиглаж, Монгол Улсын болон дипломат албаны нэр хүндэд харш, ноцтой гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд Эрүүгийн хууль, “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-д заасны дагуу хүлээлгэх хариуцлагын талаар мэдээлэл өгөх сургалтыг жил бүр зохион байгуулж хэвшсэн. Тухайлбал, “Хилийн чанад дахь ДТГ-т ажиллаж буй албан хаагчдын үүрэг, хариуцлага” сэдвээр цахим танилцуулга боловсруулж, ДТГ-уудад ажиллахаар томилогдсон 63 албан хаагчдад зориулан 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр тусгайлсан сургалт зохион байгуулав.

Хилийн чанад дахь ДТГ-т ажиллахаар томилогдсон албан хаагчид болон ДТГ-т ажиллах томилолтын хугацаа дуусч буцаж ирэх албан хаагчдын хариуцаж байсан ажил үүргийг Засгийн газрын 2019 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Дипломат ажилтны сахилгын дүрэм”-ийн 3.4.7.-д заасны дагуу хүлээлцүүлж, тэмдэглэл үйлдэж, ирүүлэхийг яамны газар, нэгжийн удирдлагууд, ДТГ-ын тэргүүн нарт чиглэл болгон хэрэгжүүлж байна.

Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичигт заасны дагуу шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангахад анхаарч ирсэн бөгөөд зарим гадаад улсад шинээр томилогдсон Элчин сайдын албан тушаалын 10 хувьд нь эмэгтэй албан хаагчийн нэр дэвшүүлж шийдэрлүүлэв.

Гадаад харилцааны Сайд Б.Батцэцэгийн санаачилгаар ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх зорилт, арга хэмжээний талаар нийт албан хаагчдын дунд санал, асуулга зохион байгуулж, дүн шинжилгээ хийх ажлыг тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар гүйцэтгэж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ